



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 11

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын наймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 374,649,188 (гурван зуун далан дөрвөн сая зургаан зуун дөчин есөн мянга нэг зуун наян найм) төгрөгийн балансын үнэтэй, 199,872,173 (нэг зуун ерэн есөн сая найман зуун далан хоёр мянга нэг зуун далан гурав) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурдсан барилга байгууламжийг акталж, данснаас хасах, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Хүмүүнлэг сургуулийн захирал (Д.Мөнхбат) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1. Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг Орон нутгийн өмчийн газар, сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, илүү гарсан хуучин материалыг худалдах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

433322025

Аймгийн иргэдийн Гөлөөлөгчдийн Хурлын
2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн
172-тогтоолын хавсралт

Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургуулийн барилга байгууламжийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	
1	Хичээлийн байр	1/1/1967	ш	1	366,205,737	366,205,737	169526026.4	196,679,711	
2	Блокон склад	1/1/1971	ш	1	748451.14	748451.14	37422.72	711,028	
3	Цэвэр бохирын шугам	12/31/2009	м	20	62000	1240000	708569.7	531,430	
4	Дулааны шугам	12/20/2017	м	35	130000	4550000	2599996.66	1,950,003	
5	Явган хүний зам	12/31/2008	ш	46	3000	138000	138000	0	
6	Цементэн талбай	12/31/2008	ш	589	3000	1767000	1767000	0	
	Нийт дүн				367,152,188	374,649,188	174,777,015	199,872,173	
	Нийт хөрөнгийн дүн					374,649,188	199,872,173	199,872,173	199,872,173
						/гурван зуун далан дөрвөн сая зургаан зуун дөчин есөн мянга нэг зуун наян найман төгрөг/		/нэг зуун ерэн есөн сая найман зуун далан хоёр мянга нэг зуун далан гурван төгрөг	



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум

Утас: 70593399, Факс: 70593232

e-mail: umch@dundgovi.gov.mn

2022.02.17

№

33

танай

-ны №

-г

**ХҮМҮҮНЛЭГ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.МӨНХБАТ ТАНАА**

Танай ирүүлсэн хүсэлтийн дагуу “Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоол гарсан тул тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлнэ үү.

Барилгыг буулгахдаа аймгийн Орон нутгийн өмчийн газар, сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг байлцуулан, тэдгээрийн хяналт дор буулгахыг анхааруулъя.

Хавсралт 2 хуудас

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ТАНТУЛГА

